

Огноо 2019.08.15

№ 19/07/002

Улаанбаатар

КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫГ СОНГОХ ТУХАЙ

Компаний тухай хуулийн 76-р зүйлийн 76.1.8 дахь заалт, ТУЗ-ийн Нэр Дэвшүүлэх Хорооноос оруулсан санал, 2019 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн цахим хэлбэрээр зохион байгуулсан ТУЗ-ийн хурлын эчнээ санал хураалтад оролцсон есөн гишүүд санал нэгтгэйгээр баталсныг үндэслэн, **ТОГТООХ НЬ:**

1. ТУЗ-ийн хурлын эчнээ санал хураалтад оролцсон нийт есөн гишүүдийн санал нэгтгэйгээр баталснаар Оргодол овогтой Амартүвшинг компанийн Гүйцэтгэх Захирлаар 2019 оны 8 дугаар сарын 19-ний өдрөөс сонгон ажиллуулсугай.
2. Гүйцэтгэх захирал шинээр томилсонтой холбогдуулан одоогийн Гүйцэтгэх захирал Мэндийн Төвшинтэй байгуулсан хөлсөөр ажиллах гэрээг 2019 оны 8 дугаар сарын 16-ны ажлын өдрийн эцсээр дуусгавар болгон цуцалж, ажлаас чөлөөлсүгэй.
3. Компанийн тухай хууль, компанийн дүрэмд нийцүүлэн гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээг хавсралтаар баталж, уг гэрээнд ТУЗ-ийг төлөөлөн гарын үсэг зурахыг ТУЗ-ийн дарга Г. Оюунболдод зөвшөөрсүгэй.
4. Компанийн тухай хууль, компанийн дүрэм, Компанийн Засаглалын Кодекс болон хөлсөөр ажиллах гэрээнд заасан чиг үүргээ хэрэгжүүлж, компанийн эрх ашгийн төлөө хичээн ажиллахыг Гүйцэтгэх Захирал О. Амартүвшинд үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Г. ОЮУНБОЛД

Огноо 2019.08.15

№ 19/08/004

Улаанбаатар

ТУЗ-ИЙН ХОРООДЫГ БАЙГУУЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 81-р зүйлийн 81.2 дахь заалт, 2019 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн цахим хэлбэрээр зохион байгуулсан ТУЗ-ийн хурлын санал хураалтад оролцсон нийт есөн гишүүний санал нэгтгэйгээр баталсан дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. ТУЗ-ийн Аудитын хорооны гишүүдээр дараах нэр бүхий гурван гишүүнийг сонгосугай.
 1. Д. Үнэнбат /Дарга, Хараат бус гишүүн/
 2. С. Батбилэг /Хараат бус гишүүн/
 3. Г. Санжаасүрэн /Ердийн гишүүн/
2. ТУЗ-ийн Нэр дэвшүүлэх хорооны гишүүдээр дараах нэр бүхий гурван гишүүнийг сонгосугай.
 1. С. Батбилэг /Дарга, Хараат бус гишүүн/
 2. Б. Баярмаа /Хараат бус гишүүн/
 3. Д. Үнэнбат /Хараат бус гишүүн/
3. ТУЗ-ийн Цалин урамшууллын хорооны гишүүдээр дараах нэр бүхий гурван гишүүнийг сонгосугай.
 1. Б. Баярмаа /Дарга, Хараат бус гишүүн/
 2. С. Батбилэг /Хараат бус гишүүн/
 3. Д. Батсайхан /Ердийн гишүүн/
4. Компанийн тухай хууль, компанийн дүрэм, хороодын үйл ажиллагааны журмаар тогтоосон үүргээ хэрэгжүүлж, компанийн эрх ашгийн төлөө ажиллахыг Хорооны дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Г. ОЮУНБОЛД

Огноо 2019.08.15

№ 19/08/001

Улаанбаатар

ТУЗ-ИЙН ДАРГЫГ СОНГОХ ТУХАЙ

Компаний тухай хуулийн 78-р зүйлийн 78.1 дэх заалт, 2019 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн цахим хэлбэрээр зохион байгуулсан ТУЗ-ийн хурлын эчнээ санал хураалтад оролцсон есөн гишүүд санал нэгтгэйгээр баталсныг үндэслэн, **ТОГТООХ НЬ:**

1. ТУЗ-ийн хурлын эчнээ санал хураалтад оролцсон нийт есөн гишүүдийн санал нэгтгэйгээр баталснаар Гомбо овогтой Оюунболдыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Даргаар сонгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Г. ОЮУНБОЛД

Огноо 2019.08.15

№ 19/08/003

Улаанбаатар

ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫГ ТОМИЛОХ ТУХАЙ

Компаний тухай хуулийн 76.1.8 дахь заалт, ТУЗ-ийн даргаас оруулсан санал, 2019 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн цахим хэлбэрээр зохион байгуулсан ТУЗ-ийн хурлын санал хураалтад оролцсон есөн гишүүний санал нэгтгэйгээр баталсан дүнг үндэслэн,
ТОГТООХ НЬ:

1. Ундармаа овогтой Анарыг ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар томилсугай.
2. Компанийн тухай хууль, компанийн дүрэм, Компанийн Засаглалын Кодекс болон ажил гүйцэтгэх гэрээнд заасан чиг үүргээ хэрэгжүүлж, компанийн эрх ашгийн төлөө хичээн ажиллахыг У. Анарт үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Г. ОЮУНБОЛД